

## МЭДЭЭЛЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖ



### АГУУЛГА

УХААЛАГ УТАС БОЛОН КОМПЬЮТЕРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ .....	2
ИНТЕРНЭТ БАНКНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖ .....	2
НУУЦ ҮГИЙН ЗӨВЛӨМЖ .....	4
АТМ-НЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖ .....	4
ТӨЛБӨРИЙН КАРТЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖ .....	5
И-МЭЙЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ.....	5

Үндэсний хөрөнгө оруулалтын банк нь харилцагчдийн санхүүгийн болон хувийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдалд онцгой анхаарч, мэдээлэл алдагдах, мэдээлэлд зөвшөөрөлгүй хандахаас урьдчилан сэргийлэн хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт техник технологи, шифрлэлтийн арга, хамгаалалтын төхөөрөмжүүдийг нэвтрүүлэн ажилладаг.

Мэдээлэл технологийн хурдацтай хөгжлийн үр дүнд банкны үйлчилгээг орон зай үл хамааран олон сувгаар, хүссэн цагтаа авах боломжтой болсон хэдий ч цахим орчинд та өөрийн хувийн болон санхүүгийн мэдээллийн аюулгүй байдлаа хангах нэн шаардлагатай. Хэрэв таны мэдээллийн нууцлал алдагдсан, сэжигтэй гүйлгээ илэрсэн тохиолдолд Үндэсний хөрөнгө оруулалтын банкны 1800-1188 утсанд даруй мэдээллэх үүрэгтэй. Харилцагч танд дараах зөвлөмжүүдийг хүргэж байна.

#### *УХААЛАГ УТАС БОЛОН КОМПЬЮТЕРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ*

- Ухаалаг утас болон компьютертоо галт хана, вирусийн эсрэг програм хангамж суулгаж, шинэчилэлтийг байнга хийж байх.
- Ухаалаг утас болон компьютерийн үйлдлийн системийн шинэчилэлтийг байнга хийж, вэб хөтчийн хамгийн сүүлийн хувилбарыг ашиглах.
- Ухаалаг утас болон компьютертоо дэлгэц түгжих нууц үг хийх ба өөр бусад нэвтрэх нууц үгтэйгээ адилханаар үүсгэхгүй байх.
- Ухаалаг утас болон компьютер идэвхгүй үед дэлгэц 2-3 минутын дараа автоматаар түгжигддэг тохиргоог идэвхижүүлэх.
- Ухаалаг утас болон компьютер дээр зөвхөн албан ёсны баталгаатай эх сурвалжаас буюу *Google Play Store, Apple App Store*-оос програм татаж суулгах, гуравдагч эх сурвалжаас програм татаж суулгахгүй байх.
- Ухаалаг утас болон компьютер дээр програм суулгахдаа ямар төрлийн зөвшөөрөл шаардаж байгааг анзаарах. *Жишээлбэл: таны хувийн нууцлалтай холбоотой мэдээллэлд нэвтрэх эрх олгогдож байгаа эсэхийг шалгах.*
- Нууц үггүй шууд нэвтэрдэг, олон нийтийн хандалттай утасгүй сүлжээг ашиглахаас зайлсхийх, баталгаат үүрэн операторын сүлжээ ашиглах.
- Ухаалаг утас болон компьютерийн *"Bluetooth"*-ийг ашиглаагүй үедээ унтрааж байх.
- Интернет банк болон цахим түрийвч үйлчилгээнд нэвтэрсэн үедээ ухаалаг утас болон компьютероо хараа хяналтгүй орхихгүй байх.
- Ухаалаг утас болон компьютер дээрээ интернет банкинд нэвтрэх нэр, нууц үг, данс, картын дугаар зэрэг мэдээллийг хадгалахгүй байх.
- Хэрэв ухаалаг утас болон компьютероо хулгайд алдсан бол интернет банкны нууц үгээ нэн даруй солих хэрэгтэй.

#### *ИНТЕРНЭТ БАНКНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖ*

- *Аюулгүй байдлын ерөнхий зөвлөгөө:*
  - Хүчирхэг нууц үг ашиглах.
  - Та интернет банкны хэрэглэгчийн нэр, нууц үгээ бусдад задруулахгүй, дамжуулахгүй байх.

- Та интернэт банкны үйлчилгээ авахдаа нууц үггүй шууд нэвтэрдэг, олон нийтийн хандалттай утасгүй сүлжээг ашиглахаас аль болох зайлсхийх хэрэгтэй. Учир нь нээлттэй утасгүй сүлжээг цацаж буй этгээд болон нээлттэй утасгүй сүлжээнд буй өөр хэн нэгэн тухайн утасгүй сүлжээгээр дамжиж буй бүх мэдээллийг чагнах, замаас нь барьж авч болзошгүй. Баталгаат үүрэн операторын сүлжээ ашиглах хэрэгтэй.
- Зайлшгүй шаардлагаар нээлттэй, олон нийтийн хандалттай утасгүй сүлжээ болон интернэт кафе зэрэг нийтийн ашигладаг компьютер дээрээс интернэт банк үйлчилгээг ашиглах тохиолдолд анхаарал болгоомжтой байж, хяналтын камерийн дуран таны компьютерийн гарыг бичих боломжгүй өнцөгт суух, интернэт банкны хэрэглэгчийн нэр нууц үгийг вэб хөтөч дээр хадгалахгүй байх, интернэт банкны үйлчилгээг ашигласны дараа системээс гарсан эсэхээ сайтар шалгах ба вэб хөтөч дээрээс хандалтын түүхийг устгаж байх хэрэгтэй.
- Та интернэт банкны үйлчилгээ авахдаа Үндэсний хөрөнгө оруулалтын банкны албан ёсны (<https://www.e-nibank.mn>) интернэт банкны вэб сайтад нэвтэрсэн эсэх, онлайн худалдан авалт хийхдээ тухайн вэб сайт SSL нууцлалын сертификатаар (вэб хаяг [https://-ээр эхлэж байгаа эсэх](https://-ээр_эхлэж_байгаа_эсэх)) баталгаажсан эсэхийг шалгаж байгаарай. Энэ нь нууцлалын алгоритмаар шифрлэлт хийн дамжуулахад ашиглагддаг бөгөөд таны оруулж буй мэдээллийг өөр хэн нэгэн гуравдагч этгээд дундаас нь барьж авч унших боломжгүй гэсэн үг юм.
- SSL нууцлалын сертификатаар баталгаажсан интернэт банкны вэб сайт доорх байдлаар харагдана. Үүнд:

#### Mozilla Firefox



#### Google Chrome



#### Internet Explorer



#### Safari



- Интернэт банкинд нэвтрэх бүрт өмнөх холбогдсон IP хаяг харагдаж байдаг. Хэрэв таны ашигладаг төхөөрөмжийн IP хаягаас өөр хаяг байвал зөвшөөрөлгүй нэвтрэлтийг мэдэх боломжтой. Иймд нэвтрэлтийн мэдээллийг шалгаж, баталгаажуулж байх хэрэгтэй.
- Өөрийн дансны үлдэгдэл, дансны хуулга зэргийг тогтмол хянаж, шалгаж байх хэрэгтэй. Данс болон картанд орлого, зарлага хийгдэх

үед харилцагчид и-мэйл болон мессежээр мэдээллэдэг миний мэдээ үйлчилгээг ашиглах хэрэгтэй. Хийгдсэн гүйлгээнд эргэлзээтэй байгаа тохиолдолд Үндэсний хөрөнгө оруулалтын банкны 1800-1188 утсанд хандан шалгуулаарай.

- Таны бүртгэлийн мэдээлэл (Утасны дугаар, и-мэйл хаяг, оршин суугаа хаяг) өөрчлөгдсөн тохиолдолд өөрт ойр байрлах Үндэсний хөрөнгө оруулалтын банкны салбарт хандан мэдээллээ шинэчилж хэвших.

### НУУЦ ҮГИЙН ЗӨВЛӨМЖ

- Та интернэт банкны үйлчилгээнд ашигладаг нууц үгээ тодорхой давтамжтайгаар сольж байх хэрэгтэй. Жишээлбэл: 1-2 сар тутам эсвэл улирал тутамд сольж байхыг зөвлөж байна.
- Интернэт банкны нэр, нууц үгээ цаасан дээр бичиж, вэб хөтөч дээрээ автоматаар сануулж хадгалах хэрэггүй.
- Та интернэт банкны үйлчилгээнд ашигладаг нууц үгээ хэн нэгэн таах боломжгүй, компьютероор тооцоолоход хүнд, төвөгтэй байдлаар буюу доорх зөвлөмжийн дагуу үүсгэвэл учирч болох эрсдэлийг бууруулахад тустай. Үүнд:
  - Интернэт банкны нууц үг хамгийн багадаа 8 тэмдэгтийн урттай
  - Том үсэг (A..Z)
  - Жижиг үсэг (a..z)
  - Тоо тэмдэгт (0123456789)
  - Тусгай тэмдэгт (!@#\$%^&\*(){}.)
  - Өөрийн болон ойр дотны хүмүүсийн нэр, утасны дугаар, төрсөн өдөр, регистрийн дугаар зэрэг хувийн мэдээлэл, дуртай зүйлс гэх мэт таах боломжтой нууц үгийг аль болох сонгохгүй байх.
  - Өөр бусад сошил хаяг, интернэт үйлчилгээнд ашигладаг нэр, нууц үгтэйгээ адилханаар үүсгэхгүй байх.

### АТМ-НЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖ

Харилцагч та АТМ-аар үйлчлүүлэхдээ дараах зөвлөмжүүдийг даган мөрдөж, учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлээрэй. Үүнд:

- АТМ сонгон үйлчлүүлэхдээ гудамж талбайн гэрэлтүүлэгтэй, үзэгдэх орчин тод байрласан АТМ ашиглах.
- АТМ-ны эргэн тойронд сэжигтэй этгээд зогсож буй эсэхийг шалгах, боломжтой бол өөрийн ойр дотны хүнтэйгээ хамт явж АТМ-аар үйлчлүүлэх.
- Утсаар ярих зэрэг анхаарал сарниулах үйлдэл хийхгүй байхыг хичээх.
- АТМ-аар үйлчлүүлэхдээ нууцлалын аюулгүй байдлын үүднээс аль болох бусдаас тусламж авах, PIN дугаараа бусдад хэлэхээс зайлсхийх.
- Ойр орчинд байгаа хүмүүс таны хийж буй үйлдлийг харах боломжгүй байрлалд зогсох.
- PIN дугаараа оруулахдаа биеэр болон гараараа хааж байх.
- Гүйлгээний баримт, хуулгыг орхилгүй, өөртөө авч явах.

- Төлбөрийн карт болон бэлэн мөнгөө марталгүй авч явах.
- АТМ-аас бэлэн мөнгө авахдаа, АТМ-ын камерын дэргэд мөнгөө тоолж авч байх.
- Гүйлгээ хийж дуусаад АТМ-аас холдон явахын өмнө карт болон бэлэн мөнгөө далд хийх.
- Хэрэв АТМ алдаатай ажиллаж мөнгө тань гарч ирээгүй, дутуу гарч ирсэн тохиолдолд төлбөрийн картаа дахин уншуулж үлдэгдлээ шалган зарлага хийгдсэн эсэхийг хянаж, Үндэсний хөрөнгө оруулалтын банкны 1800-1188 утсанд мэдэгдээрэй.
- АТМ-д нууц камер, тастатур /пин кодны мэдээллийг авах/, эд ангийг хуурамчаар дуурайлган үйлдсэн гэх мэт сэжигтэй зүйлс байгаа эсэхийг сайн нягталж харах, сэжигтэй санагдсан тохиолдолд үйлчлүүлэхгүй байх, энэ тухай Үндэсний хөрөнгө оруулалтын банкны 1800-1188 утсанд мэдэгдээрэй.
- Хэрэв төлбөрийн картаа АТМ-д хураалгасан бол Үндэсний хөрөнгө оруулалтын банкны, Цахим банкны төвийн 976-11-330434, 976-75757070 дугаарын утсанд мэдэгдээрэй.

#### *ТӨЛБӨРИЙН КАРТЫН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨМЖ*

- Төлбөрийн картыг найдвартай газар хадгалж, механик, дулаан, цахилгаан, соронзон гэмтлээс хамгаалах.
- Банкны ажилтаны дэргэд PIN дугаарын битүүмжлэл алдагдсан эсэхийг заавал шалгах.
- Төлбөрийн картын PIN дугаарыг өөрийн төрсөн огноо, утасны дугаар гэх мэт таах боломжтой тоогоор сонгохгүй байх.
- Төлбөрийн картаа хүлээн авсан даруйд өөр хүн ашиглахаас сэргийлэн төлбөрийн картын ар талд гарын үсгээ зурж баталгаажуулах.
- Төлбөрийн картыг бусдад дамжуулахгүй байх.
- Төлбөрийн картын PIN дугаараа бусдад хэлэхгүй байх, төлбөрийн карт дээрээ бичиж тэмдэглэхгүй байх.
- Картаар үйлчлэгч байгууллагын үйлчилгээний ажилтан гүйлгээний мөнгөн дүн болон харилцагчийн мэдээлэл үнэн зөв эсэхийг шалгах буюу харилцагчийн гарын үсэгтэй баримтыг харилцагчийн төлбөрийн картын ард байрлах баталгаат гарын үсэгтэй тулган шалгах хэрэгтэй.
- Интернэт банк болон миний мэдээ үйлчилгээгээг ашиглаж дансны хуулгаа тогтмол шалгаж занших.
- Хийгдсэн гүйлгээнд эргэлзээтэй байгаа тохиолдолд Үндэсний хөрөнгө оруулалтын банкны, Цахим банкны төвийн 976-11-330434, 976-75757070 дугаарын утсанд хандан шалгуулаарай.

#### *И-МЭЙЛИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ*

- Банк болон хууль хүчний байгууллагаас таны дансны нууц мэдээллийн талаар и-мэйлээр болон утсаар асуудаггүй тул дансны мэдээллээ задруулахгүй байх.

- Интернет банкны нэр, нууц үг, картын дугаар, хүчинтэй хугацаа, CVV дугаар, PIN дугаар зэрэг нууц мэдээллээ и-мэйлээр дамжуулахгүй байх.
- Танихгүй, сэжигтэй этгээдэд өөрийн и-мэйл хаягаа өгөхгүй байх.
- Өөрийн и-мэйл хаягаа олон нийтийн вэб сайт дээр ил харагдуулахгүй байх.
- Хортой и-мэйлийг хэрхэн таньж мэдэх вэ?
  - Хүний анхаарал татахуйц нэр гарчиг өгсөн байдаг. *Жишээлбэл: Нэхэмжлэх, Swift гүйлгээний баримт, Хамтран ажиллах гэрээ, Яг одоо бүртгүүлвэл хөнгөлөлттэй, Чиний зураг байна! гэх мэт.*
  - Танд их хэмжээний мөнгө өвлүүлэхээр санал болгосон, сугалаанд хожсон тул дансны мэдээллээ явуулна уу зэрэг сэжиг бүхий и-мэйлд хариу бичихгүй байх.
  - Танихгүй, сэжигтэй этгээдээс ирсэн и-мэйлд хавсаргасан линк, файлыг нээж үзэхээс аль болох зайлсхийх, хариу бичихгүй байх.
  - Агуулгыг нь нээж үзэхийн тулд маско-г идэвхжүүлэхийг шаардсан цонх гарвал маско-г идэвхжүүлэхээс татгалзах.
  - Гадаад хэлээр болон Монгол хэлээр ч хортой и-мэйл ирж болзошгүй. Энэ нь Google Translate ашигласан болов уу гэмээр өгүүлбэрийн утга алдаатай, үг үсгийн алдаа зэргээс ажиглагдана.